

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2026 оны ...сарын ...-ны өдөр
хот

Улаанбаатар

Дүрэм батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Усан замын тээврийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1."Усан замын тээврийн улсын хяналтын дүрэм"-ийг хавсралт ёсоор баталсугай.

2.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайханд даалгасугай.

Гарын үсэг

Засгийн газрын 2026 оны
... дүгээр сарын ...-ны өдрийн
... дугаар тогтоолын хавсралт

УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН УЛСЫН ХЯНАЛТЫН ДҮРЭМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1.Энэхүү дүрмийн зорилго Усан замын тээврийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн усан замын тээврийн аюулгүй байдалд хяналт хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.Усан замын тээврийн улсын хяналт /цаашид “хяналт” гэх/-ыг усан замын тээврийн хяналтын улсын ахлах байцаагч, улсын байцаагч /цаашид “улсын байцаагч” гэх/ хэрэгжүүлнэ.

1.3.Хяналтын улсын байцаагч нь Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

1.4.Усан замын тээврийн хяналт нь Усан замын тээврийн тухай хууль, дагалдан гарсан дүрэм, журам, стандартыг мөрдөж буй байдалд хяналтыг хэрэгжүүлж, тээвэрлэлтийн үйл ажиллагаа, техникийн бүрэн бүтэн байдал, ашиглалтаас шалтгаалан тээвэрлэгчийн эрх, ашгийг хохироосон зөрчлийг илрүүлж, түүнийг арилгуулахад чиглэнэ.

1.5.Хяналтын улсын байцаагч нь засгийн газраас баталсан албаны болон хувийн дугаар бүхий үнэмлэх, тэмдэг, албан шаардлага, дүгнэлт, акт, зөвлөмж, торгуулийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

1.6.Улсын байцаагчийн ажиллах нөхцлийн нэмэгдлийг тухайн албан тушаалын сарын үндсэн цалингийн 30 хувиар тооцож, зөвхөн хөвөлтийн улирлын хугацаанд олгоно.

ХОЁР. УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН УЛСЫН ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛ

2.1.Хяналтыг дор дурдсан чиглэлээр хэрэгжүүлнэ.

2.1.1.Усан замын тээврийн тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан дүрэм, журам, стандарт, шийдвэрийн биелэлт;

2.1.2.усан замын зогсоол ашиглалт, усан замын тэмдэг, тэмдэглэгээний стандартын мөрдөлт;

2.1.3.усан замын тээврийн хэрэгслийн хөвөлтийн аюулгүй байдалд тавих хяналт;

2.1.4.усан замын тээврийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага, гэрээний хэрэгжилт;

2.1.5.усан замын тээврийн болон усан замын тээврийн хэрэгслийн ашиглалтын аюулгүй байдалд тавигдах шаардлага, авран хамгаалах хэрэгслийн стандартын мөрдөлт;

2.1.6.усан замын тээврийн хэрэгслийн жолооч, мэргэшсэн жолооч бэлтгэх сургалтын үйл ажиллагааны хөндлөнгийн хяналт, чадамжийн үнэлгээ хийх, үнэмлэх олгох, ахмад, багийн гишүүдийн мэргэжлийн үнэмлэхийг шалгах;

2.1.7.усан замын тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх, тоо бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох, техник ашиглалтын хувийн хэрэг хөтлөлт.

ГУРАВ. УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

3.1.Улсын байцаагч нь Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасан улсын байцаагчийн нийтлэг бүрэн эрхээс гадна дор дурдсан эрх эдэлнэ:

3.1.1.гамшиг, аюулт үзэгдэл, усан замын тээврийн хэрэгсэл, техникийн холбогдолтой ослын нөхцөл шалтгаан, гэм буруутай этгээдийг тогтоох зорилгоор албан тушаалтан, иргэдээс тайлбар, тодорхойлолт гаргуулах;

3.1.2.албан үүргээ гүйцэтгэж буй улсын байцаагч бүрэн даатгалд хамрагдах;

3.1.3.шаардлага хангаагүй усан замын тээврийн хэрэгслийг хөвөлтөд гаргахыг хориглох, зогсоох, саатуулах.

3.2.Улсын байцаагч нь дор дурдсан үүрэг хүлээнэ:

3.2.1.энэ дүрмийн 2.1-д заасан чиглэлийн дагуу үүргээ хэрэгжүүлэх;

3.2.2.усан замын тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, илэрсэн зөрчлийг арилгуулах, таслан зогсоох арга хэмжээ авах;

3.2.3.хяналт, шалгалтын хүрээнд гаргасан дүгнэлт, шийдвэрийнхээ үнэн зөв байдлыг бүрэн хариуцах;

3.2.4.шударга, хараат бусаар ажиллаж, албан тушаалын байдлаа урвуулан ашиглахгүй байх;

3.2.5.улсын байцаагч нь албан үүргээ гүйцэтгэж, хяналт шалгалт хийх үедээ дүрэмт хувцас, ялгах тэмдэг хэрэглэх.

ДӨРӨВ. ХАРИУЦЛАГА

4.1.Улсын байцаагчийн хууль ёсны шийдвэрийг иргэн, хуулийн этгээд хугацаанд нь биелүүлж, хариуг албан ёсоор мэдэгдэх үүрэгтэй.

4.2.Хууль тогтоомж, холбогдох дүрэм, журам, стандартыг зөрчсөн, илрүүлсэн зөрчлийг арилгуулах талаар тавьсан шаардлагыг биелүүлээгүй иргэн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

4.3.Зөрчил гаргасан иргэн, хуулийн этгээд нь ногдуулсан торгууль, нөхөн төлбөрийг тогтоосон хугацаанд холбогдох дансанд шилжүүлнэ.

4.4.Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл иргэн, хуулийн этгээд гомдлоо улсын ерөнхий байцаагчид болон шүүхэд гаргаж болно.

4.5.Улсын байцаагч хууль зөрчсөн бол түүнд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

4.6.Улсын байцаагчийг дүрэмт хувцас, ялгах тэмдэг, албан үүргээ гүйцэтгэхэд нь шаардагдах автомашин, багаж, техник хэрэгслээр хангах үүргийг тухайн улсын байцаагчийг ажиллуулж байгаа байгууллага хариуцна.

---000---

ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Их Хурлаар 2017 онд Усан замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсан. Хууль батлагдсантай холбогдуулан Усан замын тээврийн тухай хууль болон түүнд нийцүүлэн гаргасан дүрэм, журмын хэрэгжилтийг зохион байгуулан ажилладаг.

Усан замын тээврийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т “усан замын тээврийн тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналтыг хэрэгжүүлэх, усан замын тээврийн улсын хяналтын дүрмийг батлах” гэж заасан.

Усан замын тээврийн хэрэгслийг үзлэг, оношилгоонд хамруулах, техникийн шаардлага хангахгүй тээврийн хэрэгслийг эрт илрүүлэх, холбогдох засвар үйлчилгээ зохион байгуулах талаар чиглэл өгөх, эрсдэлийг бууруулах болон усан замын тээврийн хэрэгслээр иргэдэд үйлчилж буй иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавих, салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгох, сурталчлах, хүний амь нас, эрүүл мэнд, байгаль орчинд ээлтэй усан замын тээврийн хөгжүүлэхэд анхаарах, салбарын хүний нөөцийг мэргэшүүлэх, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж хөтлөх, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, ил тод байдлыг хангах, эрсдэлийг бууруулах болон аюулгүй тээврийг бий болгох нь чухал ач холбогдолтой юм.

Энэхүү тогтоолд усан замын тээврийн улсын хяналтын чиглэл болон усан замын тээврийн хяналтын улсын байцаагчийн эрх, үүргийг тусгайлан зохицуулсанаараа онцлог юм.

2026 оны байдлаар Зам, тээврийн сайдын тушаалаар Усан замын тээврийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий улсын ахлах байцаагч /1/, улсын байцаагч /4/ нийт 5 байцаагчийн бүрэлдэхүүнтэйгээр Хөвсгөл аймгийн нутагт орших Хөвсгөл нуур, Архангай аймгийн нутагт орших Тэрхийн цагаан нуур, Өгий нуур, Увс аймгийн нутагт орших Хяргас нуур, Дорнод аймгийн нутагт орших Буйр нуур, Говьсүмбэр аймгийн нутагт орших Хаялага нуур, Баян-Өлгийн аймгийн нутагт орших Толбо нуур, Ховд аймгийн нутагт орших Хар-Ус, Дөргөн зэрэг нууруудад үйл ажиллагаа явуулж буй 280 гаруй усан замын тээврийн хэрэгслийн үйл ажиллагаад хөвөлтийн улиралд өдөр тутмын хяналтыг хэрэгжүүлэн ажилладаг.

Усан замын тээврийн хяналтын эрх олгосон буюу хавсран гүйцэтгэдэг улсын байцаагчтай 4 аймаг байдаг. Үүнд:

1. Архангай /автотээвэр, усан замын хяналтын улсын байцаагч/
2. Баян-Өлгий /автотээвэр, усан замын хяналтын улсын байцаагч/

3. Увс /автотээвэр, усан замын хяналтын улсын байцаагч/

4. Хөвсгөл /автотээвэр, усан замын хяналтын улсын ахлах байцаагч/

Дээрх усан замын тээврийн хяналтын улсын байцаагчид нь Төрийн хяналт шалгалтын тухай, Усан замын тээврийн тухай, Зөвшөөрлийн тухай, Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм, журмын хэрэгжилтийг хангах, холбогдох стандартын мөрдөлтийн байдалд хяналт шалгалт хийж, илрүүлсэн зөрчил дутагдлыг арилгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, цаашид авах арга хэмжээний санал боловсруулах чиг үүргийг хэрэгжүүлэн ажилладаг.

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5 дахь заалт, 2023 оны 06 дугаар тогтоолоор “Хяналтын улсын байцаагчийн эрх олгох, цуцлах журам”-аар салбарын улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагчийн эрхийг тухайн салбарын Засгийн газрын гишүүн олгож, цуцлахаар заасны дагуу эрх авсан хяналтын улсын байцаагчид Ерөнхий байцаагчийн баталсан удирдамжийн дагуу төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус болон урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийж гүйцэтгэдэг.

Салбарын ерөнхий байцаагчийн 2025 онд баталсан 04/03, 04/04 дугаартай удирдамжийн дагуу усан замын тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, иргэдийн тээвэрлэлтийн үйл ажиллагаанд Төрийн хяналт шалгалтын тухай, Усан замын тээврийн тухай хуулиуд, тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам болон стандартын мөрдөлтөд урьдчилан сэргийлэх болон төлөвлөгөөт хяналт шалгалт хийсэн. Хяналт шалгалтад 21 аж ахуйн нэгж, 1 байгууллага, 41 иргэн хамрагдсан байна.

Усан замын тээврийн хэрэгслийн улсын бүртгэлд 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар 155 аж ахуйн нэгж, байгууллага, иргэний нийт 285 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байгаа бөгөөд шинээр бүртгүүлэх-4, шилжилт хөдөлгөөн-6 нийт 10 хүсэлт, өргөдлийг И-Монголиа-аар дамжуулан хүлээн авч тус тус шийдвэрлээд байна.

Мөн хөвөлтийн аюулгүй байдалд тавих хяналтыг сайжруулах зорилгоор усан замын тээврийн хэрэгслүүдэд байршил тогтоох GPS төхөөрөмжийг суурилуулж, тээврийн хяналтын нэгдсэн удирдлагын систем нэвтрүүлэх ажлыг зохион байгууж байна.

Усан замын тээврийн хэрэгсэл ихээр төвлөрсөн Хөвсгөл нуурт усан замын тээврийн хяналтын үйл ажиллагааны техникийн хүчин чадлыг сайжруулах

зорилгоор ХБНГУ-д үйлдвэрлэсэн тусгай тоноглол бүхий аврах 3 завийг оруулж ирэн хяналтын үйл ажилалгаанд ашиглаж байна.

Усан замын тээврийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн усан замын тээврийн аюулгүй байдалд хяналт хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг тодорхой болгох зорилгоор “Усан замын тээврийн улсын хяналтын дүрэм”-ийг нийтлэг үндэслэл, усан замын тээврийн улсын хяналтын чиглэл, усан замын тээврийн хяналтын улсын байцаагчийн эрх, үүрэг, бусад зүйл гэсэн бүтэцтэйгээр боловсруулан танилцуулж байна.

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ